



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

2024.02.08 № А-1/586
танай _____-ны № _____-т

**Тендерийн баримт бичигт
өөрчлөлт оруулах тухай**

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 01/108 дугаартай албан бичгийн дагуу тус төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

- Оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлахад шаардлагатай нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй эсэх тодорхойлолтыг маягт НД-7-ын дагуу харьяа Нийгмийн даатгалын байгууллагаас авч өөрийн тендерт хавсарган ирүүлэх;
- ТШЗ 17.6.2. "Тендерт оролцогчийн үндсэн инженер техникийн ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг цахим системээр дамжуулан шалгана. Инженер техникийн ажилтнууд нь гэрээгээр ажиллах бол тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан хөлсөөр ажиллуулах гэрээг ирүүлнэ." гэснийг "Тендерт оролцогчийн үндсэн ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолтыг маягт НД-8-ын дагуу харьяа Нийгмийн даатгалын байгууллагаас авч өөрийн тендерт хавсарган ирүүлнэ." гэж өөрчлөв.

Хавсралт: 1 хуудастай.

ДАРГА



Ц.БАТЗУЛ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛЭГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024.01.12 № 01/108
танай _____-ны № _____-т

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ,
АВТО ТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВД,
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД,
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМАНД, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМАНД

Хамтран ажиллах тухай

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд ашиглагдаж буй мэдээллийн системийг цогцоор нь шинэчлэн нэвтрүүлж байгаа бөгөөд үүнтэй уялдан өмнөх системээр үүссэн өгөгдөл мэдээллийг хөрвүүлэх ажил үе шаттай хийгдэж байна.

Тус ажил 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл үргэлжлэх төлөвлөгөөтэй байгаа тул дурдсан хугацаанд ажил олгогч болон даатгуулагчийн шимтгэл төлөлтийн мэдээллийг цахимаар солилцох ажилд доголдол үүсэхээр байна.

Иймд өөрийн эрхлэх ажлын хүрээнд өмнө нь цахимаар солилцож байсан ажил олгогч болон даатгуулагчийн шимтгэл төлөлтийн холбогдох мэдээллийг харъяа Нийгмийн даатгалын газруудаас авч ашиглан хамтран ажиллана уу.

Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг шинэ программ хангамжид хөрвүүлэх ажил бүрэн хийгдэж, шинэчилсэн системийн хэвийн ажиллагаа хангагдсанаар цахим мэдээлэл солилцох боломж бүрэн хангагдана.

ДАРГА


МОНХЗУЛ